



ӨЛГИЙ СУМЫН 6 ДУГААР БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур
Утас: 94159291
Цахим хаяг:
ainurmarkhava@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/20/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 17-ноос 2 дугаар сарын 05-ны хооронд хийхээр төлөвлөж, ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 1 дугаар сарын 24-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 20-ноос 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 23-нд Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон

орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг бэлтгэхэд оршино.Хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх боловсрол эзэмшүүлэх” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн захирал нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны төсвийг аймгийн ТЭЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сан, Өлгий сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 7-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Өлгий сумын 3 дугаар бүрэн дунд сургуулийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 15 буюу “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЭЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн төсвийн захирагч нь 2017 онд 840.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 840.9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан. Оны эцэст тайлант оны үйл ажиллагаатай холбоотой 4,0 сая төгрөгийн өрийг үүсгэжээ. Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна. 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургууль нь мэдээлэлээ бүрэн оруулсан, зөрчил дутагдал гараагүй байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-ман файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 чиглэлд 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, нэмэлт санхүүжилт, цалин, НДШ, ХХОАТ, түлш халаалт, хоол, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, тэтгэврийн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд Өлгий сумын 6 дугаар сургууль байгуулагдсаны 20 ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлж, ойн арга хэмжээнд багш нараас хандив цуглуулж зарцуулсан боловч сургуулийн дансыг дамжаагүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна. Үүнд:

1. Сургуулийн тайлант оны төсөв хүрэлцээгүйн улмаас НДШ-д 2,1 сая төгрөгийн, ХХОАТ-т 4,0 сая төгрөгийн бүгд 6,1 сая төгрөгийн өглөгтэй гарсан

байна.үүний 2,1 сая төгрөг нь төрөөс олгох тэтгэмж урамшуулалтай холбоотой үүсэж, 4,0 сая төгрөг нь тайлант оны үйл ажиллагатай холбоотой үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийг бүрэн барагдуулах арга хэмжээ авах, шинээр өглөг үүсгэхгүй байх.

2.Сургууль нь 2017 онд хүмүүжлийн эрхлэгчийн албан тушаал ажилуулсан нь Боловсролын тухай хуулийн 12.3-д “ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан ажиллана” гэсэн заалттай, Хүмүүжлийн эрхлэгчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 3.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Боловсролын тухай хуулийн 43.1.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллах.

3. Сургуулийн 20 жилийн ойн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой ажилчдаас цуглуулсан хандивын тооцоог эцэслэн хийж баримтжуулаагүй байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандивын хөрөнгийн тооцоог эцэслэн хийж, баримтжуулахыг нягтлан бодогчид анхааруулав.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Дараагийн аудитаар заавал үзэх шаардлагатай анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар орон тооны асуудлыг тодруулан үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөвлөмж

Сургуулийн удирдлагад менежментийн захидлаар 1 заалт бүхий зөвлөмж өгөв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.ХУАНГАН
ОГНОО:2018.02.22
Х.ЖЕНИСБЕК
ОГНОО:2018.02.22

М.АЙНУР ОГНОО:2018.02.22